



НАЛАЙХ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 12/04

Улаанбаатар хот

Олон нийтийн хяналтын зөвлөлийн  
ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дэх хэсгийн “ж” заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4, 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2012 оны 115 дугаар тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам”-ын 5.3, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4, 9.8 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван хоёрдугаар хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Улс, нийслэл, дүүргийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын чанар, гүйцэтгэлд хяналт тавих, Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих үүрэг бүхий Олон нийтийн хяналтын зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмын дагуу хороо бүрт Олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулж, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг хороодын иргэдийн Нийтийн Хурлын дарга, Тэргүүлэгчдэд даалгасугай.

3. Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах санхүүжилтийг жил бүрийн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөвт тусгаж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга А.Булбулд даалгасугай.

4. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шаардлагатай мэдээ мэдээлэл, судалгаа, ажиллах нөхцөл боломжоор хангаж, дэмжлэг үзүүлэн ажиллахыг дүүргийн Засаг дарга Ч.Раднаабазарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.НЭРГҮЙ

Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 12/04  
дугаар тогтоолын хавсралт



## **ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх орон тооны бус Олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Олон нийтийн хяналтын зөвлөл нь Шилэн дансны үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын чанар, гүйцэтгэлд хяналт тавих, цаашид анхаарах санал дүгнэлтийг боловсруулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнах, төр-иргэний хамтын ажиллагааг бэхжүүлэх, иргэдийн оролцоотойгоор хариуцлагатай хяналттай төсвийн орчин бий болгох зорилготой ажиллана.

1.3. Олон нийтийн хяналтын зөвлөл нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, заавар, энэхүү журмыг удирдлага болгон ажиллана.

1.4. Олон нийтийн хяналтын зөвлөл нь үйл ажиллагаандаа шударга, ил тод, хараат бус байх зарчмыг баримтална.

1.5. Олон нийтийн хяналтын зөвлөл нь хяналт шалгалт, дүгнэлт, танилцуулга, зөвлөмж, баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцаж ажиллана.

### **Хоёр. Олон нийтийн хяналтын зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт**

2.1. Дүүргийн Олон нийтийн хяналтын зөвлөл нь 11 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд хорооны Хөгжлийн зөвлөлийн гишүүд нь Олон нийтийн хяналтын дэд зөвлөл /цаашид дэд зөвлөл гэх/ байна.

2.2. Дүүргийн Олон нийтийн хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын хороодын төлөөлөл, Ажлын албаны хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, иргэний оролцооны хэлтсийн мэргэжилтэн, хорооны иргэдийн Нийтийн Хурлын төлөөлөл, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

2.3. Хороодын дэд зөвлөлийн дарга, гишүүдийг хорооны Хөгжлийн зөвлөлийн гишүүдээс тухайн хороонд байнга оршин суух, санхүүгийн болон хууль эрх зүй, инженер, техникийн чиглэлийн мэдлэг, туршлагатай, мэргэшсэн иргэдээс судлан 5-7 хүнийг сонгож, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн баталгаажуулна.

2.4. Дүүргийн Олон нийтийн хяналтын зөвлөл, дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бүлэгтэй ашиг сонирхлын зөрчилтэй хамаарал бүхий этгээд орж ажиллахыг хориглоно.

2.5. Дүүргийн Олон нийтийн хяналтын Зөвлөлийн гишүүдэд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, дэд зөвлөлийн гишүүдэд хорооны иргэдийн Нийтийн Хурлын дарга үнэмлэх олгоно.

### **Гурав. Дүүргийн Олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл**

3.1. Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, илэрсэн зөрчлийн талаарх мэдээллийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнан ажиллах.

3.2. Дүүргийн хөрөнгө оруулалтын жилийн ажлын төлөвлөгөөний дагуу хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах;

3.3. Хороодын дэд зөвлөлд зөвлөмж чиглэл өгч, арга зүйн удирдлагаар ханган хамтран ажиллах;

3.4. Олон нийтийн хяналтын зөвлөлийн хуралдаанаар хороодын дэд зөвлөлийн хийсэн ажлын тайлан, хяналт шалгалтын дүнг хэлэлцэн, дүгнэлт өгч дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд тухай бүр хэлэлцүүлэх;

3.5. Идэвх санаачилгатай ажилласан дүүргийн Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүд, хороодын дэд зөвлөлийн ажлыг улирал бүр дүгнэн нэгтгэж, жилийн эцэст дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулах;

3.6. Олон нийтийн хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах санал зөвлөмжийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж, шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлэх;

3.7. Мэргэжлийн болон холбогдох байгууллагатай хамтарсан үзлэг, шалгалтын ажлыг зохион байгуулах;

3.8. Хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлт, явц, гүйцэтгэлийг олон нийтэд сурталчлах ажлыг холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран зохион байгуулах.

### **Дөрөв. Хороодын Олон нийтийн хяналтын дэд зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл**

4.1. Тухайн хороонд хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтыг Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэх, иргэдээс санал авах ажилд хяналт тавих;

4.2. Тухайн хороонд хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлыг эхлэхээс дуусах хүртэлх үе шат бүрийн ажлын чанар, явц, нөхцөл байдал, гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгөх, иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч хийгдэж буй ажлын түвшинг үнэлэх;

4.3. Тухайн хороонд хийсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах талаарх санал зөвлөмжийг хорооны иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж, шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлэх;

4.4. Хөрөнгө оруулалтын ажлын баталгаат хугацаанд хийгдэх засвар, үйлчилгээнд хяналт тавьж, санал зөвлөмжийг хорооны иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж, шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлэх;

4.5. Хөрөнгө оруулалтын ажлын явц, гүйцэтгэлийг олон нийтэд сурталчлах чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллах;

4.6. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн болон холбогдох байгууллагатай хамтарсан үзлэг, шалгалтын ажлыг зохион байгуулах;

4.7. Хөрөнгө оруулалтын ажлын явц, гүйцэтгэлд хяналт хийсэн санал, дүгнэлтээ дүүргийн Олон нийтийн хяналтын зөвлөлийн хуралдаанд тайлагнах;

4.8. Иргэдийн Нийтийн Хуралд тухайн хороонд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын чанар, гүйцэтгэлд хяналт, шалгалт хийсэн үр дүнгийн тайланг тухай бүр мэдээлж ажиллана.

#### **Тав. Олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр**

5.1. Үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Олон нийтийн хяналтын зөвлөлийн хуралдаан /цаашид “хуралдаан” гэх/ байна.

5.2. Хуралдааныг зарласнаар хийх ба гишүүдийн 60% нь хүрэлцэн ирснээр хуралдааныг хүчинтэйд тооцно.

5.3. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцож чадаагүй зөвлөлийн гишүүн хуралдаанаар хэлэлцэх асуудлаар урьдчилан саналаа хүргүүлсэн тохиолдолд зөвлөлийн дарга хуралдаанд биечлэн оролцож буй гишүүд хэлэлцэж буй асуудлаар саналаа гаргасны дараа саналаа урьдчилан хүргүүлсэн гишүүний саналыг танилцуулж тооцно.

5.4. Дэд зөвлөл нь хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлыг газар дээр нь үзэж танилцан, тэмдэглэл үйлдэж, хуралдаанаараа хэлэлцэн санал дүгнэлт, зөвлөмж гаргана.

5.5. Гүйцэтгэсэн ажлаа дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд тухай бүр тайлагнан мэдээлж ажиллана.

5.6. Хяналт шалгалт хийсэн танилцуулгыг тухай бүрд нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар олон нийтэд ил тод мэдээлнэ.



**Зургаа. Дүүргийн Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүд, хороодын дэд зөвлөлийн ажлыг дүгнэх үзүүлэлт, үнэлгээ**

6.1. Дүүргийн Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүдийн ажил дүгнэх үзүүлэлт:

6.1.1.	Төлөвлөсөн ажлын биелэлт	15 оноо
6.1.2.	Оролцоо /хуралдааны ирц, асуудал оруулсан, мэдээлэл хийсэн байдал/	10 оноо
6.1.3.	Хийсэн ажлын тайланг улирал бүрийн дараа сарын 05-ны өдрийн дотор хугацаандаа ирүүлсэн байдал	5 оноо
6.1.4.	Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьсан байдал	20 оноо
6.1.5.	Хороодын дэд зөвлөлд чиглэл, арга зүйн заавар зөвлөгөө өгч, хамтран ажилласан байдал	20 оноо
6.1.6.	Олон нийтийн хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах санал зөвлөмжийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж, шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнд хүрсэн байдал	10 оноо
6.1.7.	Мэргэжлийн болон холбогдох байгууллагатай хамтарсан үзлэг, шалгалтын ажлыг зохион байгуулсан байдал	10 оноо
6.1.8.	Олон нийтийн хяналт шалгалтын явц, үр дүнг олон нийтэд ил тод мэдээлж сурталчилсан байдал	10 оноо
	Нийт авбал зохих оноо	100 оноо

6.2. Хорооны Олон нийтийн хяналтын дэд зөвлөлийн ажил дүгнэх үзүүлэлт:

6.2.1.	Төлөвлөсөн ажлын биелэлт	15 оноо
6.2.2.	Оролцоо /хуралдааны ирц, асуудал оруулсан, мэдээлэл хийсэн байдал/	15 оноо
6.2.3.	Хийсэн ажлын тайланг улирал бүрийн дараа сарын 05-ны өдрийн дотор хугацаандаа ирүүлсэн байдал	10 оноо
6.2.4.	Иргэдийн Нийтийн Хурлаар хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, олон нийтийн хяналт шалгалт хийсэн үр дүнг тайлагнаж ажилласан байдал	10 оноо
6.2.5.	Хороонд хийгдэж буй ажлын чанар, явц, нөхцөл байдал, гүйцэтгэлд хяналт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах санал зөвлөмжийг хорооны иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж, шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнд хүрсэн байдал	25 оноо

6.2.6.	Мэргэжлийн болон холбогдох байгууллагатай хамтарсан үзлэг, шалгалтын ажлыг зохион байгуулсан байдал	10 оноо
6.2.7.	Олон нийтийн хяналт шалгалтын явц, үр дүнг холбогдох байгууллагатай хамтран олон нийтэд ил тод мэдээлж сурталчилсан байдал	15 оноо
	Нийт авбал зохих оноо	100 оноо

6.3. Дүүргийн Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүд, хороодын дэд зөвлөлийн ажлыг дүгнэж дараах байдлаар үнэлгээ өгнө.

91-100 оноо авсан бол **"А"** буюу **"Бүрэн хангалттай"**

81-90 оноо авсан бол **"В"** буюу **"Хангалттай"**

61-80 оноо авсан бол **"С"** буюу **"Дунд"**

0-60 оноо авсан бол **"D"** буюу **"Хангалтгүй"**

6.4. Дүүргийн Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүд, хороодын дэд зөвлөлийн ажлыг дүгнэж, үнэлгээний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ:

<b>"А"</b> буюу <b>"Бүрэн хангалттай"</b>	<b>Мөнгөн болон бусад хэлбэрийн шагнал олгох</b>
	<b>Төрийн болон салбарын шагнал, бусад шагналд тодорхойлох</b>
<b>"В"</b> буюу <b>"Хангалттай"</b>	<b>Мөнгөн шагнал олгох</b>
<b>"С"</b> буюу <b>"Дунд"</b>	Дутагдаж буй мэдлэг, чадвар олгох сургалтад хамруулах
<b>"D"</b> буюу <b>"Хангалтгүй"</b>	Ажил сайжруулах хугацаатай даалгавар зөвлөмж өгөх

## **Долоо. Бусад**

7.1. Дүүргийн Олон нийтийн хяналтын зөвлөлийн даргад 320000 төгрөгийн урамшуулал, хороо тус бүрийн Олон нийтийн хяналтын дэд зөвлөлд 350000 төгрөгийн унаа, хоолны зардал улирал тутам олгох ба санхүүжилтыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс санхүүжүүлнэ.

7.2. Олон нийтийн хяналтын зөвлөлийн хяналт шалгалт хийхэд шаардагдах шатахуун, бичиг хэрэг, холбоо, сургалт, хурал, зөвлөгөөн, сурталчилгааны зардлыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс санхүүжүүлнэ.

7.3. Олон нийтийн хяналтын зөвлөл, дэд зөвлөлийн ажлыг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор дүгнэн, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр ажлын үр дүнг харгалзан шагнаж урамшуулна.

7.4. Гүйцэтгэгч байгууллагад санхүүжилтийг олгохдоо хяналт шалгалт, үнэлгээний үр дүнг харгалзан олгох асуудлыг дүүргийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газар шийдвэрлэнэ.

7.5. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид "Олон нийтийн хяналтын зөвлөлийн ажиллах журам"-ыг баталж, холбогдох нэмэлт өөрчлөлтийг тухай бүр нь хууль тогтоомжид нийцүүлэн хийнэ.

**НАЛАЙХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН АЖЛЫН АЛБА**